

БАТЛАВ  
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ  
Д.БАЯРСАЙХАН  
2019 оны .... сарын .....-ны өдөр

БАТЛАВ  
“БАЯНДӨРВӨЛЖ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ  
Н.ЛХАГВАДОРЖ  
2019 оны .... сарын .....-ны өдөр

**“ГЭРЭЛГҮЙ АЙЛ ӨРХИЙГ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ АЖИЛ”-ЫН  
БАГЦ-5 ТӨВ АЙМАГ АРХУСТ СУМ НТТ-ИЙН АШИГЛАЛТЫН АРХУСТ ФИДЕРИЙН  
АТП-7052 ДЭД СТАНЦЫН 0,4 КВ-ЫН ЦДАШ-ЫН ШИНЭЧЛЭЛИЙН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар 2019 / 433

2019 оны 11 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “БАЯНДӨРВӨЛЖ” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх), дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж шилжүүлэн барих, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Төв аймаг Архуст сум НТТ-ийн ашиглалтын Архуст фидерийн АТП-7052 дэд станцын 0,4 кВ-ын ЦДАШ-ын шинэчлэлийн ажил (цаашид “ажил” гэх)-ыг 218,484,126.0 (хоёр зуун арван найман сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун хорин зургаа) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх)-өөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний үнэ 218,484,126.0 (хоёр зуун арван найман сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун хорин зургаа) төгрөг байна. 2019-2020 онд 218,484,126.0 (хоёр зуун арван найман сая дөрвөн зуун наян дөрвөн мянга нэг зуун хорин зургаа) төгрөг байх бөгөөд захиалагч өөрийн хөрөнгөөр санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ.

А. Ажил дууссаны дараа гэрээ дүгнэсэн протокол баталгаажсанаар чанарын баталгаа, зүгшрүүлэх тохируулах хугацааны барьцаа хөрөнгө болон төсөвт тусгагдсан холбогдох бусад зардлыг хасан үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

4. Гүйцэтгэгч нь Төв аймаг Архуст сум НТТ-ийн ашиглалтын Архуст фидерийн АТП-7052 дэд станцын 0,4 кВ-ын ЦДАШ-ын шинэчлэлийн ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр эхэлж, 2020 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн дотор ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).  
Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдэл; үнийн санал,
- 5.2. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.3. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.4. Төсөв, зураг;
- 5.5. Үе шатны ажлын хуваарь;
- 5.7. Бусад шаардлагатай баримт бичиг ;

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээж болно.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр боон утсан холбоогоор харилцана.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“УБЦТС” ТӨХК-ИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД  
ЗАХИРАЛ

 О.ОТГОНБАЯР

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

 О.АРИУНБОЛД

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА

 Ш.ОЮУНЧИМЭГ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Ц.ЭНХЦЭЦЭГ

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ЛХАГВАДОРЖ



Утас: 99083705,

Факс:

Хаяг: СБД дүүрэг, 6-р хороо, бага  
тойрог, Монре импекс 306-1 трот.